

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

Ц. Бавуудай

**БНХАУ ДАХЬ ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ
ЗАСАХ ОРОН**

Өвөр Монголын өөртөө засах орон байгуулагдаад эдүгээ 35 жил болж байна.

Хятадын ардын хувьсгал ялахаас өмнө эрх чөлөөгөө олсон өвөр монгол ард түмний засаг төрийг 1949 онд БНХАУ-ын засгийн газар зөвхөн автономит районы эрхтэй засаг захиргааны нэгж болгон тус улсын бүрэлдэхүүнд оруулсан билээ. Тэр үед тус өөртөө засах орон нь Хөлөн, Наун (Хөлөнбуйр, Наун Мөрөн хоёр аймгийг нэгтгэсэн нэр. -Ц. Б) Хянган, Шилийн гол, Цахар, Жирэм, Зуу-Уд зэрэг 6 аймаг, 32 хошуу, 4 сянь, 3 хот бүхий засаг захиргааны зохион байгуулалттай бөгөөд 700 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй¹ байлаа.

БНХАУ-д оршин суух хятад бус ард түмэн нь тус орны нутаг дэвсгэрийн 60 орчим хувь, хүн амын 6 орчим хувийг тус тус эзлэх бөгөөд хэл, соёл, түүхэн уламжлал, шашин шүтлэг, эдийн засаг, зан заншил болон нийгмийн бусад шинжээрээ хан үндэстнээс ялгаатай. Ялангуяа тэдгээрийн дотроос Өвөр Монгол, Синзян, Төвд зэрэг ард түмнүүд нь үндэсний онцлог болон түүх соёлоороо маш өвөрмөц юм.

Үндэстний эв нэгдлийн асуудлыг шинжлэх ухааны социализмын онол туршлагад тулгуурлан шийдвэрлэсэн нөхцөлд л олон үндэстний нэгдэл нягтрал бий болж, янз бүрийн үндэстэн харилцан ойртон нягтрах чиглэлээр хөгждөг билээ. В.И.Ленин үндэстний өөртөө засан тохинох эрхийн тухай «...тусгаарлан салах тухай асуудлыг ардчилсан аргаар бүрэн чөлөөтэй шийдвэрлэх явдлыг хуулиар хангаж өгөх...»² тухай онцлон тэмдэглэж байсан юм.

1922 онд хуралдсан ХКН-ын II их хурал, мөн 1928 онд хуралдсан ХКН-ын VI их хурлын баримт бичигт хятад биш угсаатан ястнуудад биеэ даан тусгаарлах хүртэл өөрөө засан тохинох эрх эдлүүлэх тухай заасан юм. VI их хурлаас баталсан баримт бичгийн III зүйлд дурдахдаа: «Цөөнх үндэстэн ард түмний Хятадтай нэгдэх буюу үндэстний өөрөө засан тохинох эрхийг зөвшөөрөн хүлээнэ» гэжээ. 1931 оны сүүлчээр хуралдсан Бүх хятадын зөвлөлүүдийн анхдугаар их хурлаас үндэстний асуудлаар гаргасан тогтоолд ч энэ тухай заасан байдаг. Түүнчлэн мөн хурлаас баталсан үндсэн хуулийн 14-р зүйлд: «Зөвлөлт Бүгд Найрамдах Хятад Улс бүх үндэстний өөрөө засан тохинох, салан тусгаарлаж биеэ даасан улс байгуулах эрхийг эрс шууд, үг дуугүй зөвшөөрөн хүлээнэ»³ гэжээ. Мөн Хятадын Зөвлөлүүдийн төв засгийн газраас 1935 онд Өвөр монголын ард түмэнд хандан гаргасан тунхаглалд: «Анхнаас байсан өвөр 6 чуулган, 24 аймаг, 49 хошуу хийгээд Цахар, Түмд хоёр аймаг

¹«Жэньминь шоу цэ» (ардын гарын авлага) Бээжин. 1951 он 640-р тал (хятадаар)

²В. И. Ленин. Зохиолууд. УБ. 19-р боть 443-р тал

³«Проблемы Китая» М., 1934 г. 13, с. 120.

болон Ниньсягийн зэрэг онцгой гурван хошууны бүх нутаг нь Өвөр Монгол үндэстний нутаг орон болно» гээд цааш нь: «Өвөр Монголын ард түмэн өөрийн дотоодын бүх асуудлыг шийдвэрлэх эрхтэй бөгөөд Өвөр Монгол үндэстний аж төрөх, зан заншил, шашин шүтлэг, ёс суртахуунаа эдлэх эрхийг хүчээр дарангуйлах ба хөндлөнгөөс оролцох эрх хэнд ч байхгүй. Мөн түүнчлэн Өвөр Монгол үндэстэн өөрийн хүсэлтээр эзэн хүний зарчмийн үндсэн дээр өөрийн засгийн газрыг зохион байгуулж, бусад үндэстэнтэй хөрш улсын харилцаа тогтоох буюу бүрэн салан тусгаарлах эрхтэй»⁴ гэж заасан байдаг. Гэтэл 1954 онд баталсан БНХАУ-ын анхдугаар үндсэн хуулийн 1-р бүлгийн 3-р зүйлд: «БНХАУ нь олон үндэстний нэгдмэл улс бөгөөд хягад бус үндэстний өөртөө засах орнууд нь БНХАУ-ын салшгүй хэсэг»⁵ гэж тунхаглажээ. Ингэснээр Маогийн бүлгийнхэн засгийн эрхэнд гармагц ХКН-ын урьд тунхагласан үндэстний өөртөө засан тохинох эрх, холбооны улсын байгууллын тухай ле-нинч зарчмаас ухарч дээр дурдсан үндэстнүүдэд ор нэрийн төдий автономит эрх олгосон байна.

БНХАУ байгуулагдсаны дараа хятадын удирдагчид үндэстний асуудлын тухай марксист-ленинист сургаал ба бусад социалист оронд хэрэгжиж ирсэн түүний онол практикийн ач холбогдлыг таниулан тайлбарлах ямар ч ажил зохиолгүй зөвхөн орон нутгийн чанартай автономит районыг хэдэн газар байгуулсан төдийгээр БНХАУ-ын доторхи үндэстний асуудлыг шийдсэн мэтээр орхисон билээ.

Бээжингийн эрх барих бүлэг БНХАУ-ын дотор их хан үндэстний дээрэнгүй үзэл, үйл ажиллагааг нийгэм-эдийн засаг, улс төр, соёл болон бусад талаар гүнзгийрүүлэн, хан бус олон үндэстнүүдийг хүчээр хятадчлан уусгах, тэднийг хавчин дарангуйлах чиг шугамаа улам лавшируулсаар байлаа. Үүгээр зогсохгүй тэд хан бус үндэстний нутаг орныг хөрш орнууд руу хийх түрэмгийлэлийнхээ түшиц газар болгон ашиглаж байна. Ийм бодлогод хүчтэй өртсөн үндэстний нэг бол Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО) юм. Маогийнхан Өвөр Монголын хүн амыг хятадчилахын тулд нутаг дэвсгэрийн талаар онцгой анхаарч байсныг юуны өмнө дурдах хэрэгтэй. Тэд монгол хүн амыг түргэн хятадчлан уусгах зорилгоор бүр 1950 оноос эхлэн тус районы нутаг дэвсгэрийг тэлэн өргөтгөх алхам хийв. Маогийнхан эхлээд хятадын Ба Чан, Дэхуа зэрэг сянуудыг ӨМӨЗО-д нэгтгэн нийлүүлж улмаар 1954 онд Нинся мужийн үндсэн хэсгийг, 1955 оны 7-р сард Жэхэ (халуун гол) мужийн зарим хэсгийг ӨМӨЗО-д харьяалуулжээ.⁶ Ийнхүү өөрчлөлт хийсний эцэст тус районы нутаг дэвсгэр нь 1,4 сая хавтгай дөрвөлжин км болж анх автономит район байгуулах үетэй харьцуулбал даруй хоёр дахин нэмэгдэн, 8 сая 700 мянган хүн амтай асар том «автономит район» болон өргөжив.

Энэ нь Гоминьданы засгийн газраас 1914, 1928 онуудад удаа дараа Өвөр Монголын нутгийн зарим хэсгийг хятадын мужтай нэгтгэн нийлүүлж Жэхэ, Цахар, Суйюань хэмээх гурван онцгой район болгосонтой төстэй юм. Тэр үед Чан Кайши: «Дундад Иргэн Улсад биеэ даасан үндэстэн гэж байхгүй. Цөм нэгэн том угсааны жижиг салбар болно»⁷ гэж нотлохыг оролдоходоо: «...Монголын нэг хэсэг (өвөр монголыг хэлж буй-Ц. Б) нь аль эртнээс хятадын дотоод газар болон хувираад бай-

¹«Хятадын зөвлөлүүдийн төв засгийн газраас Өвөр Монголын ард түмэнд гаргасан тунхаг бичиг» 1935 он.

²БНХАУ-ын үндсэн хууль. Бээжин 1954., 4—5-р тал.

³«Зуго» сэтгүүл, Гонконг. 1972. № 94. 5-р тал.

⁴Ү Зинхэн нарьш «Мэнгу Вэньи» (Монголын асуудал) Шанхай, 1928. 14, 15-р тал.

гаа бөгөөд гадаад аймаг биш болов»⁸ гэж тайлбарлаж байсан нь Хятадын эзэн хаадын түрэмгийлэн эзлэх хэрцгий бодлогыг үргэлжлүүлсэн хэрэг мөн. Чан Кайшигийн энэ харгис онолыг Мао Зэдун бүр 1956 онд нотлохыг оролджээ. Тэрбээр ХКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны өргөтгөсөн хуралд нууцаар тавьсан «арван их харилцаа» гэгчид энэ тухай дэвшүүлсэн байна.

Түүний зургаа дахь зүйлд: «...хүн ам ихтэй хан үндэстэн урт удаан хугацааны дотор олон үндэстний цус холилдон бүрэлдсэн юм»⁹ гэжээ. Чан Кайши, Мао Зэдун хоёрын хэлсэн үг хэллэгийн хувьд өөр боловч утгын хувьд нэгэн зорилготой нь илт байна.

Маогийн дэвшүүлсэн «арван их харилцаа» гэгч нь бүхэлдээ ЗХУ-ын эсрэг чиглэсэн зүйл байсан учир тухайн үедээ хятадын жинхэнэ коммунистуудын эсэргүүцэлтэй тулгаран няцаагдаад хав дарагдсан юм. Харин хорин жил өнгөрсний дараа Маог залгамжлан гарч ирсэн Хуа Гофэн нэн тэргүүнд Маогийн тэрхүү «арван их харилцаа» гэгчийг 1976 онд нийт- лүүлж, түүнийг өөрийн гадаад дотоод бодлогын Мөрийн хөтөлбөрийн үндэс болгосон байна. Бээжингийн эрх баригчид Өвөр Монголчуудыг хятадчлах практик ажиллагаагаа улам нарийсган түүнийгээ алхам дараалан хэрэгжүүлсээр ирэв.

Мао Зэдун санаачлан гаргасан «соёлын хувьсгал» гэгч нь Өвөр Монголын ард түмэнд цаглашгүй гай зовлон тарьсан юм. Хятадын удирдагчид «соёлын хувьсгал» гэгчээс хойш ӨМӨЗО-ыг нутаг дэвсгэрийн хувьд дахин багасгах зорилгоор хэд хэдэн зонхилох аймгуудыг хятадын мужуудад хэсэглэн харъялуулжээ. Тухайлбал Жирмийн аймгийн харъяан дахь Жаруд, Тунляо, Баарин тариат сянь ба Тунляо хотыг Гирин мужид харъяалуулаад зарим хэсгийг Ляонин мужид харъяалуулснаар Жирзм аймаг устжээ. Ийнхүү монгол аймаг хошуудыг тасдан хятад мужид харъяалуулах явдал 1969 оны сүүлийн хагас жилээс улам ширүүсэж 1970 оноос Хөлөнбуйрын ихэнх хэсгийг хятадын Хэйлунзян (хан мөрөн) мужид, түүний зарим өчүүхэн хэсгийг бас тасдан Гирин мужид харъяа- луулжээ.¹⁰ Мөн Зуу-Удын ихэнхи хэсгийг Ляонин мужид Алшаа хошууг 1956 онд Баяннуур аймагт харъялуулсан бол 1970 онд Нинся мужид, мөн Эзнээ хошууг Ганьсу мужид шилжүүлэн Баяннуур аймгийн Нинся, Ганьсу мужид тус тус шилжүүлэн захируулсан байна.¹¹ Нэг үгээр хэлэхэд ӨМӨЗО-оос даруй 600 мянган хавтгай дөрвөлжин км нутгийг тасдан авч хятад мужид нэгтгэн нийлүүлсэн байна. Мөн түүнчлэн Өвөр Монголын автономит районд харъялагдаагүй монгол хошуудад хятад нэр өгч сянь болгожээ. Жишээ нь: Горлос хойт хошууг Жаоюань сянь гэж нэрлэж хятадын Хэйлунзянь мужид нийлүүлэн нэгтгэжээ. Тийнхүү Өвөр 6 чуулганаас зөвхөн Шилийн гол, Улаанцав, Их зуу зэрэг 3 аймгийг ӨМӨЗО-ын захиргаанд үлдээсэн байна. Үүний үр дүнд Өвөр Монголын нутаг дэвсгэр нь даруй гурав дахин бага буюу 600 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй болсон байна. Тэнд оршин суудаг монголчууд нь 400 мянга шахам болон цөөрчээ. Маогийн бүлгийнхэний Өвөр монголын талаар явуулсан их гүрний жанжлах, уусган хайлуулах түрэмгий балмад бодлогыг хятад дахь монгол хүн ам олон жилийн турш шийдвэртэй эсэргүүцэж ирсэн юм. Энд ганц жишээ дурьдахад 1964 онд

Чан Кайши. «Жунгожи миньюн» (Дундад улсын хувь заяа) Шанхай. 1945. 2-р тал.

Мао Зэдунгийн түүвэр зохиол. V боть. Бээжин, 1977. 278-р тал.

Зинь Ди «Нэймэнгу зи зы чю ди зиньси» Өвөр Монголын Автономит районы эрт эдүгээ», «Цзуго» сэггүүл № 94. 1972 Гонконг, 9-р тал.

«Маоизм, маогийнхан» УБ. 1974. 155-р тал.

Өвөр Монголын Хорчин баруун гарын дундат хошуу болон хятадын Гириин мужийн хооронд хилийн нилээд ширүүн маргаан гарсаны улмаас түүхийн архив баримт бичиг шүүхэд хүрсэн байна.¹²

Учир иймд Маог залгамжлагч хятадын одоогийн эрх баригчид Лин Бяо, «дөрвийн бүлэг»-т өмнөх бүх алдаатай бодлогоо тохоод тэдгээр алдаа дутагдлыг засч залруулахыг сүүлийн үед амлаж эхлэв. Тэдний явуулж байгаа өнгөц арга хэмжээ нэн тэргүүнд ӨМӨЗО-ны засаг захиргааны талаар ХКН-ын Төв Хороо, Төрийн Зөвлөлөөс гаргасан мэдэгдэлд тус-галаа оллоо. 1979 оны 7-р сард ХКН-ын Төв Хороо, Төрийн зөвлөлөөс гаргасан мэдэгдэлд: «Ляонин мужийн захиргаанд оруулсан Зуу-Уд, Гириин мужийн захиргаанд оруулсан Жирмийн аймаг ба Хорчин баруун гарын өмнөт хошуу, Тү цюань сянь, Хар мөрөн мужийн захиргаанд оруулсан Хөлөнбуйр аймаг, Орчооны автономит хошуу, Морин Даваагийн Дагуур автономит хошуу. Ганьсу мужид оруулсан Эзнээ хошуу, Алшаа баруун хошуу, Нинсягийн Хотон үндэстний автономит район дахь Алшаа зүүн хошуу зэргийг 1969 оны 7-р сараас өмнө байсны нэгэн адил 1979 оны 7-р сарын 1-нээс эхлэн Өвөр Монголын Өөртөө Засах Засгийн Ордоны харъяанд эргүүлэн оруулсугай»¹³ гэжээ. Хятадын удирдагчид дээр дурьдсан шийдвэр гаргасан төдийгээр Өвөр Монголын ард түмний сэтгэл санааг засахыг горьдсон бололтой. Ийм арга хэмжээ авч явуулсны учир хятадын харъят ӨМӨЗО-ы монгол хүн ам одоо 2 сая 20 мянга болж, газар нутаг нь барагцаалбал 1.2 сая хавтгай дөрвөлжин км хэмжээтэй болоод байна. Газар нутаг хүн ам богино хугацаанд ингэж өссөн явдал Бээжингийн эрх баригчдаас монгол үндэстнийг уусгах талаар явуулж байгаа ээлжит нэг зальт арга гэдгийг хэлэх хэрэгтэй. Бээжингийн эрх баригчид Өвөр Монголын автономит районыг хятадын салшгүй хэсэг хэвээр байлгахын тулд монгол үндэстний боловсон хүч-ний талаар бүр ч нарийн зальхай бодлого явуулж байна. Тэд «үсрэнгүй давшилт», «ардын коммун» гэгч адал балмад явдлын үеэс эхлэн Өвөр Монголын автономит районы эрх мэдэл, үндэстний онцлогийг бүр хайхрахгүй орхиж амьдралын бүх хүрээнд хятадчилах явдлыг хүчээр тулган хүлээлгэх бодлогоо гүнзгийрүүлэн явуулав. Маогийнхан Өвөр Монголын ард түмэнтэй харилцахдаа хүний эрхийн хэм хэмжээг дээд зэргээр зөрчин доромжилсон үйл ажиллагаа явуулж ирсэн юм. Тэд ӨМӨЗО-ны удирдах албанд хятад хүмүүсийг томилон ажиллуулах явдлыг бүр 1950-иад оноос эхлэв. Тэр цагаас хойш хятад кадр боловсон хүчнүүд өвөр монголд улам их ирдэг болов. Үүний зэрэгцээ орон нутагтаа ажиллаж байсан монгол боловсон хүчнүүдийг «туршлага солилцох» нэрийдлээр хятадын гүн нутаг руу албадан шилжүүлэх болов. Ялангуяа «соёлын хувьсгал» гэгчийн үед Маогийн эрх барих бүлгийнхэн ӨМӨЗО-ны нам төр, олон нийтийн байгууллага, цэргийн дарга зэрэг хариуцлагатай ажилтан, хувьсгалын зүтгэлтнүүдийг «хар хэрэгтэн», «буруу санаатан», «улсаас урвагчид» гэх мэтийн зүсэн зүйлийн ял оноон ахмад, дунд насны кадр ажилтан сэхээтнүүдийг бараг цөмийг хэлмэгдүүлсэн учраас одоо кадр ажилтан, төрөл бүрийн мэргэжлийн сэхээтэн их дутагдаж байна. Иймээс хятадын эрх баригчид сүүлийн үед хятад сэхээтэн залуучуудыг тус оронд үй олноор ирүүлдэг боллоо. ӨМӨЗО-анх байгуулагдсан 1947 онд тус орны засгийн газрын гишүүн 21 хүний 18 нь монгол хүн байсан¹⁴ бол «соёлын хувьсгал» гэгчээс хойш ӨМӨЗО-нд монгол үндэстний

¹² «Баба жаньбао» улаан хамгаалагчийн сонин. Бээжинд. 1967. 8. 4. (хятадаар)

¹³ «Жэньминь жибао» 1979 оны VII сарын 21.

¹⁴ «Сосайти» сэтгүүл 1971. № 10

боловсон хүчин бараг байхгүй болж ганц хоёрын зэрэг монгол хүн чимэг болон үлджээ. ӨМӨЗО-ны нам, засаг захиргааны байгууллагын гол удирдах хүмүүс нь цөм хятад үндэстний кадр ажилтнууд байна.

Одоогийн байдлаар Өвөр Монгол сэхээтнүүд «соёлын хувьсгал» гэгчийн үед хэлмэгдэгсэд ба «гавьяа» байгуулагчид гэдэг хоёр бүлэгт хуваагдаад байна. Хятадын эрх баригчид «соёлын хувьсгалын» үед хэлмэгдээд амьд үлдсэн зарим хүнийг цагаатган, хуучин ажилд нь эргүүлэн оруулж байгаагийн зэрэгцээ тэднийг ашиглахын тулд хэлмэгдсэний «хохирол»-ыг төлөх ёстой хэмээн мөнгөн хахуул өгдөг боллоо.

Бээжингийн эрх баригчид Өвөр Монголын хэлмэгдсэн ард түмэнд хэдийгээр энэ мэт мөнгөн «хахуул» өгч байгаа боловч хэлмэгдэгсэдийн бие сэтгэлд үлдсэн шарх сорив, гомдол тийм ч амархан арилахгүй байна. Нөгөө талаар «соёлын хувьсгал»-аар ихээхэн зүтгэл гарган «гавьяа» байгуулсан хүмүүс одоо болоход буруутан болоод байгаа нь бас л тэдэнд гомдол хорсол, сэтгэл нь дундуур байхын үндэс болж байгаа ажээ. Бодит байдал ийм байгаа учраас Бээжингийн эрх баригчид тэднийг бүрмөсөн гомдоочихгүйг хичээн төдийлөн буруушаахгүй, харин ч битүүхэндээ «сайшаах» дүр үзүүлж, хожмын ирээдүйд тэднийг дахин ашиглах зорилго тавьж тал засаж байж ч болох юм.

«Соёлын хувьсгал» гэгчийн үед хамгийн их хэлмэгдсэн үндэстэн бол Өвөр Монголчууд юм. Одоо тэр бүхний бурууг хэдийгээр Лин Бяо, «дөрвийн бүлэгт» тохоод Маог ямар ч гэм буруугүй болгохыг хятадын эрх баригчид хичээж байгаа боловч үнэн хэрэг дээр Өвөр Монголын соёлын талаар чухал чухал асуудлыг Мао Зэдун өөрийн дур зоргоор шийдвэрлэдэг байсан тухай хятадыг судлаач өрнөдийн түүхчид ч тэмдэглэсэн байдаг.¹⁵

Маогийн «цус холилдон» уусгах бодлогыг Өвөр Монголд ихээхэн хэрэгжүүлж иржээ. Ялангуяа «соёлын хувьсгал» гэгчээс хойш бүр ч ширүүссэн билээ. Үүнийг бээжингийн эрх баригчид одоо ч огт буруушаахгүй харин ч дэмжин сайшааж байна. Үүний нэг жишээ бол Хүннүгийн үед хятадын хан улсын хаанаас монголыг татахын тулд Хүннүгийн шаньюйд гүнжээ хатан болгон өгсөн явдлыг сайшаан магтах болж тэр тухай өгүүлэл бичиж нийтэлсний зэрэгцээ 1980 онд «Ван Чжаоцзюнь» гэдэг жүжиг зохион тайзнаа голлож эхлэв. Уг жүжгийг хятадын эрх баригчид ихэд сайшаан, Жоу Энлайн амьд ахуйдаа гэрээсэлж байсан зүйл өнөөдөр биеллээ олж байна гэж сонин хэвлэлд сурталчилах болжээ.

Бээжингийн эрх баригчид монгол үндэстнийг уусгах бодлогодоо Өвөр Монголын бэлчээр нутгийг хагалан тариалан явдлыг ихээхэн чухалчилдаг юм. Хятадын эрх баригчдийн Өвөр Монголын бэлчээр нутгийг хагалбарлан тариалангийн талбай болгох ажиллагаа аль 50-иад оны сүүл 60-аад оны үеэс хэрэгжиж ирсэн юм. Тэр нь «соёлын хувьсгал» гэгчийн үед бүрч ширүүсэж, атар нутгийг хагалж үлэмж хэмжээний бэлчээрийг эвдэн сүйтгэжээ. Жишээ болгон дурьдахад зөвхөн Их зуу аймагт 1972 он хүртэл 40 сая му¹⁶ атар газар хагалж 6 сая гаруй му бэлчээрийг эвдсэн байна. Энэ явдлыг Өвөр Монголын ард түмэн эрс эсэргүүцсээр иржээ. ӨМӨЗО-ны мал аж ахуй эрхэлсэн томоохон аймгийн нэг болох Хөлөнбуйрт 1979 оны үед мөн л атар хагалж бэлчээр нутгийг ихээхэн сүйтгэсэнтэй холбогдсон эсэргүүцэл гарсны улмаас хятадын засгийн газар тусгай комисс томилон явуулж шалгуулахад хүрчээ.

1980 оны 8-р сард хуралдсан БХАТХ-ын тав дахь удаагийн сонгуулийн гуравдугаар чуулганд оролцсон Өвөр Монголын төлөөлөгч Ин-

¹⁵ В. Хайсаг. «Монголын түүх ба соёл» (Япон хэлнээ нийтлүүлсэн эх) Токио. 1967. 68-р тал.

¹⁶ нэг му 6, 144 а-тай тэнцэнэ.

хуа (Мөнгөнцэцэг) хэлэхдээ: «Малчдаас үхэр хонь худалдан авахдаа үнэ өртөгийн талаар дарамт шахалт үзүүлж байна. Үүнийгээ «монгол наймаа» гэж нэрлэж байгаа нь үнэн хэрэгтээ цөөн тоот үндэстнийг доромжилж байгаа хэрэг бөгөөд малчин ардын эрх ашгийг шууд хөсөрдүүлж байна.¹⁷ гэжээ. Дээрхи санал шүүмжлэл нь Өвөр Монголын үнэн байдлын зөвхөн зах зухыг цухалзуулж байгаа юм. Чухам хэрэг дээрээ Бээжингийн засгийн газраас Өвөр Монголд явуулж байгаа худалдаа арилжааны талын тэгш бус, шулан мөлжих явдал зөвхөн сүүлийн жилүүдэд бий болж байгаа үзэгдэл огтхон биш юм. Бүр соёлын хувьсгалаас өмнө тус районы дарга агсан Улаанхүү: «Одоогийн Өвөр Монгол дахь ху- далдааны байдал дээр үеийн «Даашинхүү пүүсний хандлагатай байна.¹⁸ гэж хэлснээс болж «соёлын хувьсгалын» үед Улаанхүүд оноосон 100 ялын нэгд тэр хэлсэн үг нь орсон билээ. Маог залгамжилж буй хятадын шинэ эрх баригчид анх гарч ирэх үедээ гоё сайхан амлалт өгч үндэстний бодлогыг өөрчлөн сайжруулах тухай ярьж байсан боловч тэр нь хоосон ам- лалт байсныг өнөөгийн байдал илхэн харуулж байна. Энэ тухай хятадын сонин ч нуулгүй бичиж байна. Тухайлбал Өвөр Монголын ард түмэн Хятадын үндсэн хуульд заасан автономит эрхээ эзэн хүний ёсоор эдлэхийг хүсч, ядуу зүдүү хоцрогдлын байдлаа түргэн арилгаж өгөхийг шаардаж байна.¹⁹ Нөгөө талаар ӨМӨЗО-д хятад хүн урсгалаар орж ирж байгаа явдлыг даруй зогсоож энэ талаар арга хэмжээ авахыг хүсэхийн зэрэгцээ үндэстний боловсон хүчин кадрыг бэлтгэж өгөх, үндэстний соёлын өвийг хамгаалж, хэл бичиг соёлыг хөгжүүлж, зан заншил, шашин шүтлэгийг хүндэтгэхийг хүсч байгаа тухай «Жэньминь жибао» сонинд тэмдэглэжээ.²⁰ Мөн хан үндэстний кадр, үндэстний автономит районы талаар хайхрамжгүй хандаж байдаг тухай бичсэн байна. Энэ бүхнээс үзсэн ч Бээжингийн одоогийн эрх баригчдын үндэстний талаар баримталж байгаа бодлого нь аанай л Маогаас өвлөн авсан үндэстэн ястныг ялгаварлан гадуурхаж хүчээр хятадчилан устгах, нутаг орныг нь хөрш орнууд руу хийх түрэмгийллийнхээ түшиц газар болгон ашиглахад чиглэсэн бодлогын үргэлжлэл болж байна. Үүнийг хятадын төв хэвлэлүүд ч ийнхүү нуухгүй бичиж байна. Тэд: «Өвөр Монгол бол империализм, ревизионизмын эсрэг тэмцэх тэргүүн шугам юм. Өвөр Монголыг империализм, ревизионизмтэй тэмцэх ган төмөр хэрэм болгон бай- гууль»²¹ «дэлхийн дайн гарах аюул их болж байна»²² гэх мэт уриа гаргаж энэ үндсэн дээр Өвөр Монголыг хилийн район, хаалттай бүс болгон цэрэгжүүлж байна.

Өвөр Монголын өрхийн цэрэг нь гранат шидэх, танк эсэргүүцэх дэлбэлэлт хийх зэрэг байлдааны ажиллагааг шамдан суралцаж байна. Тус районы коммуны үйлдвэрлэлийн бригад бүрт өрхийн цэргээс гадна байнгын цэргийн анги байрлаж байна.²³ Хилийн районы орчим өрхийн цэргийн харуулын газар байдаг бөгөөд тэнд өрхийн цэргүүд очиж 1-2 сарын хугацаагаар хилийн цэрэгтэй хамтран харуулын үүрэг гүйцэтгэдэг байна.

Өвөр Монголд цэрэг стратегийн холбогдолтой зам холбоо онгоцны буудал зэрэг барилга байгууламж ихээр байгуулж байгаагаас гадна агаарын дайралтаас хамгаалах нуувч нүх шуудуу, тусгай бэхлэлтийг энд тэнд-

¹⁷ «Жэньминь жибао» 1980. 9. 15.

¹⁸ «Ба ба жан бао» сонин 1967. 8. 4

¹⁹ «Жэньминь жибао» 1981. 7. 14.

²⁰ Мөн сонин 1981. 7. 14.

²¹ «Жэньминь жибао» 1977. 7. 31.

²² Мөн сонин. 1979. 7. 31.

²³ «Үнэн» 1979. 7. 25.

гүй байгуулж байна. Мөн түүнчлэн Өвөр Монголын газар нутгийг янз бүрийн зэвсэг турших туршлагын талбай болгон хувиргажээ. Өвөр монгол дахь дайны бэлтгэл нь юуны урьд ЗХУ, БНМАУ-ын эсрэг шууд чиглэж байна. Хятадын өнөөгийн эрх баригчдын хятад биш үндэстний талаар явуулж байгаа адал балмад хуурамч бодлогыг Өвөр Монголын ард түмэн эрс эсэргүүцэн тэмцсээр байна.

АВТОНОМНЫЙ РАЙОН ВНУТРЕННЯЯ МОНГОЛИЯ

Резюме

На II-ом и VI-ом съездах КПК, 1-ом съезде Всехитайских советов в 1931 году, так и в обращении правительства и центрального советского района к народу Внутренней Монголии в 1935 г. было особо выделено право, проживающих в Китае наций, на самоопределение. Однако сразу после прихода к власти Мао Цзэдуна, в 1-ой Конституции КНР 1954 года было оговорено, «что автономные районы КНР являются ее неотделимой составной частью».

Внутренняя Монголия вошла в состав КНР на правах Автономного района после победы народно-демократической революции в Китае.

С начала 50-х годов начинается административная, перекройка, территории Внутренней Монголии, которая продолжается и в период «культурной революции», в результате чего часть мангольской территории попала под административное управление Китая.

Однако после прихода к власти нынешнего руководства, ЦК КПК и Госсовет КНР в 1979 году опубликовали декрет, по которому территория Внутренней Монголии в СССР танавливалась в границах 1969 года. Таким образом на сегодняшний день территория АРВМ составляет 1,2 млн. км²., на которой проживает более 18 млн. человек.

Резкое увеличение населения АРВМ связано, в первую очередь, с переселением китайцев, другими словами, политикой ассимиляции, которую проводит китайское руководство. Политика ассимиляции с начала 50-х годов проводилась под вывеской «кадровой политики». На всех ступнях управленческого аппарата монголы были постепенно замещены китайскими «кадрами» и на сегодняшний день из членов правительства Автономного района лишь один-два принадлежат к монгольской национальности. Суть закона общественного развития по-пекински-есть физическое растворение малых наций, их культуры и традиций, подрыв экономики и традиционных методов ведения хозяйства.

Внутренняя Монголия занимает особое место и во внешней политике современного китайского руководства. Они называют АРВМ «передней линией фронта борьбы с империализмом и ревизионизмом». На территории этого Автономного района прокладываются шоссе и дороги стратегического назначения, строятся военные объекты и проводятся военные учения и маневры. Несомненно, что военные приготовления во Внутренней Монголии направлены против МНР и Советского Союза.

Национальная политика пекинского руководства во Внутренней Монголии есть составная часть его общей великоханьской политики в отношении национальностей, населяющих КНР.